



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Investing in rural people



МОНГОЛЫН
БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН
НЭГДСЭН ХОЛБОО


ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилтээр ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн Нэмэлт санхүүжилт нь 2018 оны 05 сараас 2021 оны 09 сар хүртэл хугацаанд нийт 6 аймгийн 18 суманд хэрэгжинэ.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төсөлд хамрагдсан аймаг, сумдын малчид болон орлого багатай иргэдийн ядуурлыг бууруулж амьжиргааг дээшлүүлэх явдал юм.

ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БАЙГАА



Аймаг	Сум
Архангай	Эрдэнэмандал, Хайрхан, Төвшрүүлэх
Дорнод	Халхгол, Хөлөнбуйр, Сэргэлэн
Дундговь	Дэлгэрцогт, Эрдэнэдалай, Сайхан-овоо
Өвөрхангай	Тарагт, Төгрөг, Хархорин
Хэнтий	Батширээт, Норовлин, Өмнөдэлгэр
Сүхбаатар	Түвшинширээ, Эрдэнэцагаан, Баяндэлгэр

Зах зээл бэлчээрийн удирдлага төсөл үндсэн гурван бүрэлдэхүүн хэсэгтэй.

Бэлчээрийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд бэлчээрийн 144 малчны бүлэг байгуулж, бүлгийн 3 жилийн төлөвлөгөөг оролцооны аргаар боловсруулж, малчид, сумын удирдлагад зориулсан бэлчээр, мал аж ахуй, эрсдлийн менежментийн багц сургалтуудыг зохион байгуулах Малчдын бүлгийн хуримтлалын санг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахад чиглэсэн хөрөнгө оруулалтуудыг сумын болон бүлгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хэрэгжүүлэх ажлыг Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо хамтран хэрэгжүүлж байна.

НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилтээр ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн Нэмэлт санхүүжилт нь 2018 оны 05 сараас 2021 оны 09 сар хүртэл хугацаанд нийт 6 аймгийн 18 суманд “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо” болон Хөгжлийн оньсон түлхүүр төв” ТТБ нь хамтран хэрэгжүүлж байна.

Төсөл хэрэгжиж байгаа аймаг, сумд

Аймаг	Сум
Архангай	Эрдэнэмандал, Хайрхан, Төвшрүүлэх
Дорнод	Халхгол, Хөлөнбуйр, Сэргэлэн
Дундговь	Дэлгэрцогт, Эрдэнэдалай, Сайхан-овоо
Өвөрхангай	Тарагт, Төгрөг, Хархорин
Хэнтий	Батширээт, Норовлин, Өмнөдэлгэр
Сүхбаатар	Түвшинширээ, Эрдэнэцагаан, Баяндэлгэр

Төслийн зорилго

Төсөлд хамрагдсан аймаг, сумдын малчид болон орлого багатай иргэдийн ядуурлыг бууруулж амьжиргааг дээшлүүлэх явдал юм. Зах зээл бэлчээрийн удирдлага төсөл үндсэн гурван бүрэлдэхүүн хэсэгтэй.

Бүрэлдэхүүн хэсгүүд

Бүрэлдэхүүн хэсэг 1. Бэлчээрийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох

Бэлчээрийн 144 малчны бүлэг байгуулж, бүлгийн 3 жилийн төлөвлөгөөг оролцооны аргаар боловсруулж, малчид, сумын удирдлагад зориулсан бэлчээр, мал аж ахуй, эрсдлийн менежментийн багц сургалтуудыг зохион байгуулах Малчдын бүлгийн хуримтлалын санг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахад чиглэсэн хөрөнгө оруулалтуудыг сумын болон бүлгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хэрэгжүүлнэ. Үүнд: гүн өрмийн худаг шинээр гаргах, засварлах, бороо цасны ус цуглуулах хөв цөөрөм байгуулах, хадлангийн нөөц талбайг хамгаалтад авах, бага оврын трактор олгох, бог мал угаах цэг байгуулах, үлийн цагаан оготонотой тэмцэх, тэжээлийн аюулгүйн нөөцийн агуулах, саравч барих, эрсдэлийн сан байгуулах, мал үржлийн дэмжлэг үзүүлэх, малчдад зориулсан мэдээллийн төв байгуулах зэрэг ажлууд орж байна.

Бүрэлдэхүүн хэсэг 2. Зах зээлийн хөгжил

Эмэгтэйчүүд давамгайлсан бүлгүүд, хөдөөгийн бичил, жижиг аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжиж, зах зээлд нэвтрэхэд нь туслах хөрөнгө оруулалт, чадавч бэхжүүлэх ажлуудыг хэрэгжүүлнэ. Бүлэг хоршоод, жижиг аж ахуйн нэгжүүдийг зээл, зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамруулж бүлгүүдийн хуримтлалын санг хадгаламж, зээлийн хоршоотой холбоход дэмжлэг үзүүлнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 3. Бизнесийн орчин сайжруулах ба бренд бүтээгдэхүүн хөгжүүлэх

Сүү, жимс, жимсгэнэ хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээний хөгжлийг дэмжих, төслийн орон нутгийн бренд бүтээгдэхүүнийг тодорхойлох, хөрөнгө оруулалт хийх, зах зээлд нэвтрэх, тэлэхэд нь дэмжлэг үзүүлэх, бренд бүтээгдэхүүний зах зээлийн орчинг сайжруулах, бичил жижиг бизнес эрхлэгчдийн батлан даалттай зээлд хамруулах г.м